



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Гадаадын иргэнийг саатуулах байрны дотоод журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга /Ц.Амгаланбаяр/, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга /Д.Мерен/ нарт даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Журам батлах тухай" Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 122 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ

Doctushaal Said. 2017 он

08 0073

ГАДААДЫН ИРГЭНИЙГ СААТУУЛАХ БАЙРНЫ ДОТООД ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан үндэслэлийн дагуу гадаадын иргэнийг /цаашид "саатуулагдсан этгээд" гэх/ саатуулах байранд хүлээн авч саатуулах шийдвэрийг хэрэгжүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын нэгжийг гадаадын иргэнийг саатуулах байр /цаашид "саатуулах байр" гэх/ гэнэ.

1.2. Саатуулах байрны үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль болон энэ журмыг мөрдөнө.

1.3. Саатуулах байр нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн дэргэд ажиллана. Баривчлах төвийн төсөвт саатуулах байрны харуул хамгаалалт, өдөр тутмын үйл ажиллагаа явуулах урсгал зардлыг тусган санхүүжүүлнэ.

1.4. Саатуулах байрны ажилтнуудын ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолт цагийн хуваарь, дотоод дэг журам, хөтлөх бүртгэлийн маягтыг саатуулах байрны дарга энэ журамд нийцүүлэн батална.

1.5. Саатуулагдсан этгээдийг суллах, гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн /цаашид "хяналтын улсын байцаагч" гэх/ мэдэлд түр шилжүүлэх, эргэлт, уулзалтын маягтыг Гадаадын иргэн, харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Хяналт шалгалтын нэгжийн дарга, саатуулах байрны даргатай зөвшилцөж батална.

1.6. Саатуулах байрны үйл ажиллагаанд харьяалах прокурор хяналт тавина.

Хоёр. Саатуулагдсан этгээдийг хүлээн авах, өрөөнд хуваарилах

2.1. Гадаадын иргэнийг саатуулах тухай шүүх /шүүгч/-ийн, хяналтын улсын байцаагчийн шийдвэр нь уг иргэнийг саатуулах байранд хүлээн авах үндэслэл болно.

2.2. Саатуулагдсан этгээдийг саатуулах байранд хүлээн авахдаа дор дурдсан журмыг баримтална:

2.2.1. саатуулагдсан этгээдийг саатуулах байрны жижүүр, эмч хүлээн авч, жижүүр нь энэ тухай бүртгэл хөтөлж, уг этгээдийг хүргэж ирсэн хяналтын улсын байцаагчаар уг бүртгэлд гарын үсэг зуруулж баталгаажуулна;

2.2.2. саатуулах байрны эмч нь хүлээн авч буй саатуулагдсан этгээдийг мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгаж, биед нь үзлэг хийж биеийн ерөнхий эрүүл мэндийн байдал, ил шарх сорви, өвчин зовиур байгаа эсэхийг шалгаж, тэмдэглэл үйлдэн уг тэмдэглэлд саатуулагдсан этгээд болон хяналтын улсын байцаагчаар гарын үсэг зуруулж баталгаажуулна;

2.2.3.саатуулах байрны жижүүр хүлээн авч буй саатуулагдсан этгээдийн биед болон авч яваа эд зүйлсэд үзлэг, нэгжлэг хийж, хориотой эд зүйлс байвал хураан авч, энэ тухай тэмдэглэл хөтлөн уг этгээд болон хяналтын улсын байцаагчаар гарын үсэг зуруулж баталгаажуулна. Хураан авсан хориотой эд зүйлсийг хадгалах, устгах асуудлыг холбогдох хуульд нийцүүлэн гаргасан тусгай журмаар зохицуулна. Саатуулагдсан этгээдийн биед хийх үзлэг, нэгжлэгийг тухайн этгээдтэй ижил хүйсийн ажилтан гүйцэтгэнэ;

2.2.4.саатуулах байрны хүлээн авах өрөөнд дотоод дэг журам, цагийн хуваарь, холбогдох хууль тогтоомжийг англи, орос, хятад, солонгос, вьетнам болон шаардлагатай бусад хэлээр бичиж байрлуулсан байх бөгөөд шаардлагатай гэж үзвэл саатуулах байрны жижүүр саатуулагдах этгээдэд дээрх мэдээллийг бичгээр танилцуулж, гарын үсэг зуруулна;

2.2.5.хяналтын улсын байцаагч нь саатуулагдсан этгээдийн талаар бүртгэл хөтөлнө;

2.2.6.хяналтын улсын байцаагч нь байрны жижүүрт хүлээлгэн өгсөн цагаас хойш 24 цагийн дотор прокурор, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ар гэр, өмгөөлөгч, тухайн улсын элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн болон консулын газар болон бусад шаардлагатай газарт шуурхай мэдэгдэнэ;

2.3.Саатуулах байранд саатуулагдаж байгаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг тусад нь байрлуулна. Саатуулагдсан этгээдэд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэлд нь тохирсон түр саатуулах байрыг сонгох боломжийг олгоно.

2.4.Саатуулах байранд дараах тохиолдолд саатуулагдсан этгээдийг хүлээн авахаас татгалзана:

2.4.1.сүрьеэ, арьс өнгөний болон бусад халдварт өвчтэй;

2.4.2.сэтгэцийн эмгэгтэй, эмнэлэгийн хяналтад байдаг талаарх нотлох баримт бичигтэй;

2.4.3.жирэмсэн;

2.4.4.насанд хүрээгүй этгээд;

2.4.5.мансууруулах бодис, согтууруулах ундаа хэрэглэсэн;

2.4.6.артерийн даралт ихсэх өвчний 2 ба 3 дугаар зэрэгтэй;

2.4.7.яс, булчин болон тулгуур хөдөлгөөний эрхтэн тогтолцооны бэртэл, гэмтэлтэй бөгөөд эмчийн үзлэгээр зайлшгүй хэвтэж эмчлүүлэх шаардлагатай гэж тогтоогдсон.

Гурав. Саатуулах байрны нөхцөл

3.1.Саатуулах байр нь дараах нөхцөлийг хангасан байна:

3.1.1.өрөө нь төмөр сараалжин хаалгатай гадна талаасаа цоожтой, цонх нь төмөр сараалжин хамгаалалттай;

3.1.2.агааржуулах салхивчтай;

3.1.3.хүйтний улиралд 18 хэмээс доошгүй дулаантай;

3.1.4.нэг хүнд 2.5 ам метрээс доошгүй талбай ногдохоор тооцсон;

3.1.5.зориулалтын ор, хувийн эд зүйлс хадгалах шүүгээтэй;

3.1.6.шаардлагатай эм, эмнэлэгийн хэрэгсэл бүхий эмийн сантай;

3.1.7.шашны зан үйл хийх тусгай өрөөтэй байх;

3.1.8.эргэлтээр ирсэн хүнтэй уулзах тусгай эргэлтийн өрөөтэй байх.

3.2.Саатуулах байр нь саатуулагдсан этгээдийн эд зүйлийг хадгалах өрөө, номын сан, ариун цэврийн шаардлага хангасан нийтийн бие засах газар, усанд орох шүршүүр, саатуулагдсан этгээдийг салхилуулах зориулалтын талбайтай байна.

3.3.Саатуулах байр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй байж, "Орчны хүртээмж ба MNS 6055-2009 стандарт"-ад нийцүүлэн тохижуулагдсан байна.

3.4.Саатуулах байр нь захиргааны журмаар түр саатуулах өрөөтэй байна.

Дөрөв. Саатуулах байрны захиргааны эрх, үүрэг

4.1.Саатуулах байрны захиргаа нь дараах эрх, үүрэгтэй байна:

4.1.1.саатуулагдсан этгээдэд саатуулах байрны дотоод дэг журмыг сахих талаар шаардлага тавих;

4.1.2.саатуулагдсан этгээдийн биеийн эрүүл мэндийн байдлын улмаас хугацаанаас нь өмнө суллах талаар хяналтын улсын байцаагчид болон прокурорт санал тавих;

4.1.3.саатуулах байрны үйл ажиллагааны талаар саатуулагдсан этгээдээс гаргасан санал хүсэлт, гомдлыг шийдвэрлэх, шаардлагатай бол холбогдох байгууллагад 72 цагийн дотор шилжүүлэх, уламжлах;

4.1.4.саатуулагдсан этгээд өдөрт ногдох хоол, хүнсээ хэрэглэхээс, шаардлагатай эмийн болон эмчилгээ хийлгэхээс татгалзсан тохиолдолд хяналтын улсын байцаагчид танилцуулна;

4.1.5.саатуулах байрны дотоод журам зөрчсөн, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан, оргон зугтахыг завдсан, бусдыг уриалан дуудсан этгээдийг бусдаас тусгаарлах. Тусгаарлах өрөөний нөхцөл нь ердийнхтэй адил байна;

4.1.6.саатуулагдсан этгээдийн эрх, эрх чөлөөг хүндэтгэж хүнлэг харьцах;

4.1.7.саатуулагдсан этгээд өвдсөн тохиолдолд саатуулах байрны эмчийн дүгнэлтийг үндэслэн эмчлүүлэх боломжоор хангах арга хэмжээ авах.

Тав. Хяналтын улсын байцаагчийн эрх, үүрэг

5.1.Хяналтын улсын байцаагч дараах эрх, үүрэгтэй байна:

5.1.1.саатуулагдсан этгээд нь оргон зайлах, төрийн албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн тохиолдолд хуульд заасан үндэслэл, журмын дагуу тусгай хэрэгсэл, мэх хэрэглэж холбогдох арга хэмжээг авах;

5.1.2.ажлын зайлшгүй шаардлагаар саатуулагдсан этгээдийг саатуулах байрны даргын зөвшөөрлөөр саатуулах байрнаас гадагш авч явахдаа аюулгүй байдлыг хангаж, буцаан хүлээлгэж өгөх;

5.1.3.саатуулагдсан этгээдийн зөрчлийг арилгуулах зорилгоор холбогдох байгууллага, албан тушаалтан болон иргэнтэй уулзалт зохион байгуулах;

5.1.4.саатуулагдсан этгээдийн талаарх хувийн мэдээллийг саатуулах байрны захиргаанд мэдээлэх;

5.1.5.саатуулагдсан этгээдтэй саадгүй уулзах, бусадтай уулзуулах зөвшөөрөл олгох;

Зургаа. Саатуулагдсан этгээдийн эрх, үүрэг

6.1.Саатуулагдсан этгээд дараах эрх, үүрэгтэй байна:

6.1.1.саатуулах байрны үйл ажиллагааны талаар гомдол, санал гаргах;

6.1.2.харьяалах улсын Элчин сайдын яамны ажилтан, өмгөөлөгч, орчуулагч, хэлмэрч, болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэнтэй уулзах, холбоо барих;

6.1.3.эмнэлгийн тусламж авах;

6.1.4.шаардлагатай эмийг эмчийн хяналтын дор зохих тунгаар, цагийн хуваарийн дагуу хэрэглэх;

6.1.5.саатуулах байрны дотоод дэг журам, цагийн хуваарийг дагаж мөрдөн, захиргаанаас тавьсан шаардлагыг биелүүлэх;

6.1.6.түр олгосон эд зүйлийг зориулалтын дагуу ашиглах, ерөө тасалгааны ханан дээр зурах, эд зүйлсийг эвдэж гэмтээхгүй байх, гэмтээсэн тохиолдолд нөхөн төлөх;

6.1.7.өрөөг бохирдуулахгүй байх;

6.1.8.бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, хэт чанга ярихгүй байх.

6.2.Саатуулагдсан этгээд дараах хувийн хэрэгцээний эд зүйлтэй байна:

6.2.1.нэг удаагийн солих хувцас;

6.2.2.аяга, халбага, шүдний оо, сойз, саван, алчуур болон зайлшгүй шаардлагатай ариун цэврийн хэрэгсэл;

6.2.3.хүчирхийлэл, садар самууныг сурталчилснаас бусад өдөр тутмын сонин, ном, сэтгүүл, шашны ном, бичгийн цаас, дугтуй, харандаа.

Долоо. Хориглох зүйл

7.1.Саатуулах байранд дараах зүйлийг хориглоно:

7.1.1.өөрийн болон бусдын эрүүл мэнд, бие эрхтэнд хохирол, гэмтэл учруулж болох зэвсгийн чанартай эд зүйл;

7.1.2.согтууруулах ундаа;

7.1.3.бэлэн мөнгө;

7.1.4.эмчийн зөвшөөрснөөс бусад төрлийн эм, мансууруулах үйлчилгээтэй бүтээгдэхүүн;

7.1.5.гэрэл зургийн болон дуу, дүрс бичлэгийн техник хэрэгсэл, гар утас;

7.1.6.тамхи, асаагуур;

7.1.7.лаазалсан болон нөөшилсөн мах, махан бүтээгдэхүүн, түргэн муудах хүнсний зүйлс;

7.1.8.өмдний тэлээ, гутлын үдээс, хумсны хутга, нүдний шил, үнэртэй ус болон хурц иртэй эд зүйлс.

Найм. Саатуулагдсан этгээдийн ахуй хангамж, үйлчилгээ

8.1.Саатуулагдсан этгээдийн хүнсний хангамж:

8.1.1.саатуулагдсан этгээдэд өглөө 200 граммаас багагүй хэмжээтэй хуурай хүнс, өдөр, орой 500 граммаас багагүй хэмжээтэй халуун хоолоор хангана. Халуун цай, усыг тухай бүрт олгоно. Хоол нь 3400 ккал-аас багагүй илчлэгтэй байна;

8.1.2.саатуулагдсан этгээдэд өгч буй хоолны илчлэгийг хоол бэлтгэн нийлүүлэгч тал улиралд нэг удаа мэргэжлийн хяналтын байгууллагаар шалгуулж, баримтжуулан саатуулах байрны захиргаанд хүлээлгэж өгнө.

8.2.Саатуулах байрнаас үзүүлэх ахуйн үйлчилгээ:

8.2.1.саатуулагдсан этгээдэд зориулсан телевизийн нэвтрүүлэг үзэх, номын сангаар үйлчлүүлэх, усанд оруулах, салхилуулах, эргэлт, уулзалтыг саатуулах байрны дотоод дэг, цагийн хуваариар зохицуулна;

8.2.2.саатуулах байрны даргын баталсан хуваарийн дагуу саатуулагдсан этгээдийг өдөрт 1 цаг хүртэл хугацаагаар салхилуулах бөгөөд саатуулагдсан этгээд салхлахаас татгалзаж болно. Байгаль, цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд салхилуулах асуудлыг саатуулах байрны дарга тухай бүр шийдвэрлэнэ;

8.2.3.саатуулагдсан этгээдийг 7 хоногт 2-оос доошгүй удаа халуун усанд оруулна;

8.2.4.саатуулагдсан этгээдэд түр эзэмшихээр ор, дэвсгэр, хөнжил, цагаан хэрэглэлийг картаар олгож, чөлөөлөгдөх үед нь хураан авна.

8.3.Төлбөртэй үйлчилгээ:

8.3.1.саатуулагдсан этгээд нь нэрийн данстай байж болно;

8.3.2.саатуулах байрны жижүүрийн хяналтад ахуйн хэрэгцээний худалдааны цэг ажиллуулж болох ба саатуулагдсан этгээд нь нэрийн данснаасаа бэлэн мөнгө авч хүнс, хувийн хэрэгцээний эд зүйл худалдан авч болно;

8.3.3.саатуулах байрны захиргаа нь телевиз, ус буцалгагч, угаалга зэрэг ахуйн хэрэгцээний зүйл бүхий төлбөртэй өрөө ажиллуулж болно;

8.3.4.төлбөртэй үйлчилгээ үзүүлэх журмыг саатуулах байрны дарга батална.

Ес. Эргэлт, уулзалт

9.1.Саатуулагдсан этгээд амралтын өдрөөс бусад өдөр ажлын цагаар 1 цагаас дээшгүй хугацаагаар хяналтын улсын байцаагчийн зөвшөөрлөөр уулзалт, эргэлт авах эрхтэй байна. Уулзалтын өдрүүд, утсан холбоогоор харилцах, захидал, цахилгаан, илгээмж дамжуулах болон цагийн хуваарийг тус тус саатуулах байрны дарга батална.

9.2.Хяналтын улсын байцаагчийн хүсэлтээр саатуулагдсан этгээдийн зөрчлийг арилгуулах, хяналт, шалгалт явуулах, гарын хурууны хээ, гэрэл зураг авах, нотлох баримт бүрдүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэнтэй уулзуулах зорилгоор саатуулах байрны даргын зөвшөөрлөөр саатуулах байрнаас гаргах, оруулахад бүртгэл хөтөлнө.

9.3.Эргэлт, уулзалтын нэгдсэн бүртгэлийг жижүүр хөтөлнө.

9.4.Саатуулах байрны жижүүр нь эргэлт, уулзалтаар хүлээн авсан эд зүйлд үзлэг, нэгжлэг хийж, хориотой эд зүйлсийг хураан авч, эргэлт, уулзалтаар ирсэн этгээдэд буцаан өгнө.

Арав. Саатуулах байрны хамгаалалт

10.1.Саатуулах байр нь байнгын харуул хамгаалалттай байх бөгөөд гэрэлтүүлэг, дохиолол, теле хяналтын хэрэгслийг хамгаалалтад ашиглана.

10.2.Саатуулах байрны жижүүр нь утсан болон радио холбооны бусад хэрэгсэл, тусгай хэрэгсэлтэй байна. Тухайлбал, гав, бороохой, нэг хүнд болон олон хүнд нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, резинэн ба хуванцар сумтай буу зэрэг.

10.3.Саатуулах байранд гэмт хэрэг, үймээн гарвал саатуулах байрны жижүүр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шуурхай удирдлагын төвийн жижүүр, тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

10.4.Саатуулагдсан этгээдэд тусгай хэрэгслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэглэж болно.

10.5. Байгалийн гамшиг гэнэтийн аюул бүхий онцгой нөхцөл үүссэн тохиолдолд ажиллах төлөвлөгөө, үйл ажиллагааны журмыг Гадаадын иргэн, харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга саатуулах байрны даргатай хамтарч баталж, мөрдүүлнэ.

10.6. Саатуулах байранд Гадаадын иргэн, харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтан, прокурор, дуудлагын эмчээс бусад гадны хүнийг зөвшөөрөлгүй нэвтрүүлэхийг хориглоно.

10.7. Монгол Улсад суугаа гадаад улсын Элчин сайд, дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллага, өмгөөлөгч, үйлчилгээний ажилтанг зохих журмын дагуу саатуулах байрны захиргаанд мэдэгдсэний үндсэн дээр саадгүй нэвтрүүлнэ.

10.8. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, ажилтныг саатуулах байранд саадгүй нэвтрүүлнэ.

Арван нэг. Саатуулагдсан этгээдийг суллах

11.1. Саатуулагдсан этгээдийг дараах тохиолдолд суллана:

11.1.1. Монгол Улсаас албадан гаргах шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор;

11.1.2. саатуулагдсан этгээд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.5-д заасны дагуу барьцаа гаргасан бол;

11.1.3. саатуулах үндэслэл арилсан бол;

11.1.4. прокурор үндэслэлгүй саатуулсан гэж үзэн суллах шийдвэр бичгээр өгсөн бол;

11.2. Саатуулагдсан этгээдийг энэ журмын 11.1.1-11.1.3-т заасан үндэслэлээр суллах тохиолдолд Хяналт шалгалтын нэгжийн даргын бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу суллах бөгөөд энэ тухай жижүүр бүртгэл хөтөлнө.

11.3. Энэхүү журмын 4.1.4-т заасан нөхцөл байдал үүсэн зайлшгүй суллах тохиолдолд хяналтын улсын байцаагч нь дээд шатны албан тушаалтанд яаралтай танилцуулж, энэ тухай прокурор, шүүгчид мэдэгдэнэ.

Арван хоёр. Саатуулах байранд хөтлөх баримт бичгийн жагсаалт

12.1. Саатуулагдсан этгээдтэй холбогдуулан саатуулах байранд дараах баримт бичгийг хөтөлнө:

12.1.1. саатуулагдах этгээдийг хүлээн авсан бүртгэл;

12.1.2. эмчийн үзлэг, эмнэлэгийн тусламж үзүүлсэн бүртгэл;

12.1.3. жижүүрийн тэмдэглэл, илтгэх хуудас;

12.1.4. саатуулагдсан этгээдээс гарсан санал, хүсэлт, гомдлын бүртгэл;

12.1.5. түр хураан авсан бэлэн мөнгө болон эд зүйлийн бүртгэл;

12.1.6. эргэлт, уулзалтын бүртгэл;

12.1.7. саатуулах байранд нэвтрэгсэдийн бүртгэл;

12.1.8. хяналтын улсын байцаагчид түр шилжүүлсэн бүртгэл;

- 12.1.9.түр хугацаагаар саатуулсан бүртгэл;
- 12.1.10.салхинд гаргасан бүртгэл;
- 12.1.11.усанд оруулсан бүртгэл;
- 12.1.12.хоолны дээж устгасан бүртгэл;
- 12.1.13.сувилагчийн бүртгэл;
- 12.1.14.холбогдох хууль, дүрэм, журам танилцуулсан бүртгэл;
- 12.1.15.тусгай хэрэгсэл, мэх хэрэглэсэн бүртгэл;
- 12.1.16.тусгаарлах ерөөнд саатуулагдсан этгээдийн бүртгэл;
- 12.1.17.үзлэг, нэгжлэг хийсэн бүртгэл.

12.2.Саатуулах байр нь саатуулагдсан этгээдийн бүртгэлийн сантай байна.

---oOo---